



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийнхураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/100/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Лхагвацэнд Утас: 261805 Цахим хаяг: <a href="mailto:khagvatsendb@audit.gov.mn">khagvatsendb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Д.Цэгмиддорж Утас: 263533 Цахим хаяг: <a href="mailto:tsegmiddorjd@audit.gov.mn">tsegmiddorjd@audit.gov.mn</a> Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 93099119 Цахим хаяг: <a href="mailto:info@ghtaudit.mn">info@ghtaudit.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ  
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН  
АЛБА ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Э.МӨНХНАРАН ТАНАА

2024.03.15 № 07/740  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Дулааны цахилгаан түгээх станц-3 ТӨХК-иас 5.0 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үнэ төлбөргүй шилжигдэн ирсэн автомашиныг Батлан хамгаалахын сайдын 2023 оны 10 сарын 12-ны өдрийн Н/92 тушаалаар данс бүртгэлд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нийт орлогыг 908.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 879.8 сая төгрөг, 28.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар батлуулж, гүйцэтгэлээр 734.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 857.0 сая төгрөгийн зардал гарган, 123.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 3 зорилт 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,177,454,030.80	1,550,570,410.46
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		4,865,342.95
1.1.4	Бусад авлага	1,516,473.44	516,473.38
1.1.6	Бараа материал	40,748,013.58	95,563,574.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	386,647,937.19	489,832,588.19
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,606,366,455.01</b>	<b>2,141,348,389.06</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	241,777,146.87	103,144,288.45
1.2.2	Биет бус хөрөнгө	13,074,166.69	7,664,166.73
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>254,851,313.56</b>	<b>110,808,455.18</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,861,217,768.57</b>	<b>2,252,156,844.24</b>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	1,003,654,695.24	1,569,492,310.43
2.1.1.3	Татварын өр	7,197,656.69	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,036,999,315.10	
2.1.1.9	Нөөц/ өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	40,393,820.69	32,701,826.37
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,088,245,487.72</b>	<b>1,602,194,136.80</b>
<b>2.2.20</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,088,245,487.72</b>	<b>1,602,194,136.80</b>
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	125,043,641.34	125,043,641.34
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	24,496,368.57	24,496,368.57
2.3.9	Хуримтлагдсан ашиг	623,432,270.94	500,422,697.53
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>772,972,280.85</b>	<b>649,962,707.44</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,861,217,768.57</b>	<b>2,252,156,844.24</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>855,684,613.55</b>	<b>627,846,524.66</b>
2	Борлуулалтын өртөг	62,597,799.49	8,417,465.40
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>793,086,814.06</b>	<b>619,429,059.26</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	99,613,590.38	106,148,120.95
6	Бусад орлого		
7	Борлуулалт маркетингийн зардал		
8	Ерөнхий ба удирдлагын зардал	652,531,081.56	698,180,749.84
9	Санхүүгийн зардал		
10	Бусад зардал		
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/		
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/	(116,875.00)	(129,903,426.48)
13	Бусад ашиг (алдагдал)	(7,196,898.00)	(20,502,577.30)
14	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>232,855,549.88</b>	<b>(123,009,573.41)</b>
15	Орлогын татварын зардал	23,285,554.98	
16	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>209,569,994.90</b>	<b>(123,009,573.41)</b>
17	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>209,569,994.90</b>	<b>(123,009,573.41)</b>
18	Бусад дэлгэрэнгүй орлого		
19	Бусад олз, гарз		
20	<b>Орлогын нийт дүн</b>	<b>209,569,994.90</b>	<b>(123,009,573.41)</b>
21	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	<b>0</b>	<b>0</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	125,043,641.34	24,496,368.57	414,772,749.63	564,312,759.54
2	Залруулсан үлдэгдэл				0.00
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-910,400.00	-910,400.00
4	Зарласан гнгол ашиг				0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт			-	0.00
6	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			209,570,000.00	209,570,000.00
7	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	125,043,641.34	24,496,368.57	623,432,349.63	772,972,359.54
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
9	Залруулсан үлдэгдэл	125,043,641.34	24,496,368.57	623,432,270.94	772,972,280.85
10	Бусад дэлгэрэнгүй орлого			-	-
11	Өмчид гарсан өөрчлөлт				
12	Зарласан гнгол ашиг				-
13	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
14	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			(123,009,573.41)	(123,009,573.41)
15	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	125,043,641.34	24,496,368.57	500,422,697.53	649,962,707.44

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>781,897,689.12</b>	<b>1,881,017,026.23</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	774,521,066.12	495,453,026.40
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	7,376,623.00	1,331,060,783.24
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		54,503,216.59
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>615,566,250.12</b>	<b>1,386,815,125.39</b>
	Ажиллагчдад төлсөн	205,707,831.57	240,627,648.73
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	40,151,496.03	47,772,276.90
	Бараа материал худалдан авахад төлсөн	99,014,560.90	146,995,646.00
	Ашиглалтын зардалд төлсөн	17,628,353.43	13,645,970.84
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	77,504,682.47	91,769,321.00
	Татварын байгууллагад төлсөн	30,198,278.81	36,590,431.07
	Даатгалын төлбөр төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	145,361,046.91	809,413,830.85
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>166,331,439.00</b>	<b>494,201,900.84</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>110,681,767.09</b>	<b>106,148,120.95</b>
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого	110,681,767.09	106,148,120.95
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,264,000.00</b>	<b>6,490,000.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,264,000.00	6,490,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>106,417,767.09</b>	<b>99,658,120.95</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,685,098,767.91</b>	<b>592,745,579.00</b>
	Бусад	1,685,098,767.91	592,745,579.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>8,455,570,781.02</b>	<b>1,813,489,221.13</b>
	Төлсөн ногдол ашиг		
	Бусад	8,455,570,781.02	1,813,489,221.13
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(6,770,472,013.11)</b>	<b>(1,220,743,642.13)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(6,497,722,807.02)	(626,883,620.34)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		(626,883,620.34)

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Зардлын төрөл, ангилал	Гүйцэтгэл 2022 он	2023 оны		Өсөлт +/-, бүүралт +/-	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	774,521,066.12	98,750,000.00	105,109,074.00	11,489,962.74	1.1
2	Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, хөтөлбөр	7,376,623.00	300,000,000.00	224,505,616.40	11,489,962.74	0.7
3	Харилцах дансны хүүгийн орлого	110,681,767.09	100,000,000.00	106,148,120.95	11,489,962.74	1.1
4	Бусад орлого	-	410,000,000.00	298,231,834.26	11,489,962.74	0.7
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>892,579,456.21</b>	<b>908,750,000.00</b>	<b>733,994,645.61</b>	11,489,962.74	0.8
1	Цалингийн зардал	223,479,057.85	297,993,656.00	286,503,693.26	11,489,962.74	96.1
2	ЭМ, НДШ	20,849,191.10	37,249,207.00	24,795,716.80	12,453,490.20	66.6
3	Элэгдлийн зардал	37,517,176.56	38,000,000.00	50,631,692.90	(12,631,692.90)	133.2
4	Ашиглалтын зардал	10,852,943.02	12,208,800.00	9,460,680.80	2,748,119.20	77.5
5	Засвар үйлчилгээний зардал	323,100.00	70,560,000.00	764,000.00	69,796,000.00	1.1
6	Бичиг хэргийн зардал	6,609,000.00	6,238,000.00	5,577,060.00	660,940.00	89.4
7	Албан томилолтын зардал	43,990,173.00	76,390,000.00	93,736,920.00	(17,346,920.00)	122.7
8	Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн зардал	10,395,390.00	2,976,000.00	-	-	-
9	Шуудан холбооны зардал	2,849,533.41	1,800,000.00	3,649,890.04	(1,849,890.04)	202.8
10	Сургалтын зардал	30,927,752.00	4,500,000.00	7,853,000.00	(3,353,000.00)	174.5
11	Автомашини шатахуун зарцуулалтын норм	29,554,589.47	34,740,000.00	32,838,404.00	1,901,596.00	94.5
12	Шатах тослох материалын зардал	7,249,300.00	21,780,000.00	19,395,400.00	2,384,600.00	89.1
13	Гатвар хураамж /Тээврийн хэрэгсэл/	4,200,000.00	3,000,000.00	2,200,000.00	800,000.00	73.3
14	Сэлбэгийн зардал /Тээврийн хэрэгсэл/	58,067,654.00	46,000,000.00	39,657,086.00	6,342,914.00	86.2
15	Гүйцэтгэлтэй холбоотой зардал	62,597,799.49	58,161,230.00	8,417,465.40	49,743,764.60	14.5
16	Материал, хангамж	73,780,877.23	39,272,000.00	17,532,876.00	21,739,124.00	44.6
17	Бусад зардал	133,552,848.61	128,905,000.00	253,990,333.82	(125,085,333.82)	197.0
	<b>Нийт зардал</b>	<b>756,796,385.74</b>	<b>879,773,893.00</b>	<b>857,004,219.02</b>	22,769,673.98	97.4

### 3. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7.5 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 07.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Мянган төгрөг

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогод биетээр тоологдсон, тайлан бүртгэлд тусгагдсан автомашин нь 2024 онд болсон ослын улмаас шатсан тул аудитын явцад байхгүй байна	1	5,000.0					1	5,000.0				
Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад тодруулга тайланд зардлыг дутуу бүртгэсэн байна	1	0					1	-				
Зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу	1	2,532.0					1	2,532.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>7,532.0</b>					<b>3</b>	<b>7,532.0</b>				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 157 мэдээллэхээс 155 мэдээллийг хугацаанд нь мэдээлэлж, өмнөх оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гэсэн 2 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсанд зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Мянган төгрөг

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 157 мэдээллэхээс 155 мэдээллийг хугацаанд нь мэдээлэлж, өмнөх оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гэсэн 2 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсанд	1	-					1	-
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>			-	-				

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.